



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 14 өдөр

Дугаар Н/79

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн 2.6.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй "Юби фүүд фестиваль" олон үндэстний хоолны өдөрлөг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Арга хэмжээний төсөв болох 9.600.000 /есөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/ - д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА





“ЮБИ ФҮҮД ФЕСТИВАЛЬ” ОЛОН ҮНДЭСТНИЙ ХООЛНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2015.07.16

Улаанбаатар хот

ЗОРИЛГО:

“Юби фүүд фестиваль” арга хэмжээ нь нийгэмд чиглэсэн, ашгийн бус олон нийтийн арга хэмжээ бөгөөд Монгол хоолны соёлыг гадаад, дотоодод таниулах, бусад улс орнуудын хоолны соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн зохистой хооллолтын талаарх ойлголтыг дээшлүүлэх, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой.

ОРОЛЦОГЧИД БА ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү өдөрлөгт Улаанбаатар хотод монгол хоол болон олон үндэстний хоолоор үйлчилдэг шилдэг ресторан, зоогийн газрууд, төрөл бүрийн хүнс, нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд оролцоно. Өдөрлөгийн үеэр аж ахуйн нэгжүүд өөрсдийн нэрийн бүтээгдэхүүн болсон хоол хүнс төдийгүй бусад улс үндэстний төрөл бүрийн хоол, зууш, амттаныг багасгасан хэмжээтэйгээр бэлтгэж хямд үнээр иргэдэд үйлчилнэ. Арга хэмжээний үеэр зохиогдох урлаг, соёлын тоглолт, үзүүлбэр үзэх, тэмцээн уралдаанд оролцоходоо иргэд төлбөр, хураамж төлөхгүй.

ХУГАЦАА:

“Юби фүүд фестиваль” арга хэмжээг Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Вива сити хороололд 2015 оны 8-р сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- MCS Properties, MCS Estates, MGC ХХК-иуд
- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Нийслэлийн Соёл, урлагийн газар
- Монголын тогооч нарын холбоо

МЭДЭЭЛЛИЙН ИВЭЭН ТЭТГЭГЧ :

- С1 телевиз

ШИЛДЭГ ОРОЛЦОГЧ ШАЛГАРУУЛАХ:

Уг өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдэд хамгийн чанартай, амтлаг хоол хүнсээр хурдан шуурхай үйлчилж, олны талархлыг хүлээсэн аж ахуйн нэгжүүдийг шилдэг оролцогчоор шалгаруулна. Мөн иргэдийн дунд олон төрлийн уралдаан, тэмцээн зохион байгуулна.


ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИХ ШААРДЛАГА:

- Хууль, журам, стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг байх
- Нэгээс доошгүй жил хоол үйлдвэрлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай байх
- Өдөрлөгийн үеэр эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан хоол, хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх, хоол, үйлчилгээ үзүүлэх явцад гарч болох аливаа хүндрэл, эрсдлийг урьдчилан тооцоолж бэлтгэлийг хангасан байх
- Нэг төрлийн хоолны үнийг 3000 төгрөгөөс хэтрүүлэхгүй байх
- Согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх

ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСНААР ГАРАХ ҮР ДҮН:

- Олон орны хоол, үйлчилгээний соёлыг иргэдэд танилцуулж, сурталчилна.
- Иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, жуулчид, монголд оршин суугаа гадаадын иргэдийн сонирхлыг татах арга хэмжээтэй болно.
- Аялал жуулчлалын идэвхтэй улирлын хугацааг уртасгахад түлхэц үзүүлнэ.

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 08 сарын 14
өдрийн 1/29 тоот тушаалын хоёрдугаар
хавсралт



“ЮБИ ФҮҮД ФЕСТИВАЛЬ” ОЛОН
ҮНДЭСТНИЙ ХООЛНЫ ӨДӨРЛӨГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын төсөв	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Асар майхан 3х3м түрээслэх	27	100,000	2,700,000
2	Асар майхан 5х5м түрээслэх	25	140,000	3,500,000
3	Үндсэн тайзны засал, камер, хөгжим, техник хэрэгсэл түрээс	1	2,500,000	2,500,000
4	Жижиг тайзны засал, хөгжим, техник хэрэгсэл түрээслэх	1	900,000	900,000
Бүгд				9,600,000